

Хурга махлуулж, борлуулах нь газрын доройтлыг бууруулж, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг дээшлүүлэх загвар болох нь


“Алсын хараа – 2050” бодлогын баримт бичигт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжих зорилтыг дэвшүүлжээ.

Үүний тулд тулд малын тоог бэлчээрийн даацтай нийцүүлж, нэмүү өртөг шингэсэн өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бүтээмж, чанарт суурилсан үйлдвэрлэлд шилжих шаардлага урган гарч байна.

1. Бэлчээрийн даац хэтрэлт түүний сөрөг үр дагавар

Малын тоо толгой огцом өссөн явдал бэлчээрийн даац хэтрэх гол шалтгаан болж байна. Малын тоо 10 хүрэхгүй жилийн дотор хоёр дахин нэмэгдэж, бэлчээрийн доройтлын улмаас малын тэжээлийн хангамж зохистой тэжээллэгийн шаардлагаас үлэмж доогуур түвшинд буурчээ (Зураг 1).

Зураг 1 Малын тоо ба тэжээлийн хангамж, 2010-2019 оны байдлаар



Эх сурвалж: Малын тоог ҮСХ-ны мэдээллээс авав. УЦУОШГ-аас гаргасан бэлчээрийн ургацын мэдээллийг ашиглан тэжээлийн хангамжийг БСТ-өөс тооцсон болно.

- 2021 оны байдлаар малын тоо 67 сая болсноор тэжээл хангамж 45% болж, 1 хонины тэжээлийг 2.2 хонь хувааж байгаагаас давжаарч, ашиг шим буурч байна.
- Ухаалаг бодлого биш, харин зуд малын тоог “зохицуулж”, тэжээлийн архаг дутагдлыг зөөллөж ирлээ.
- 2004-2014 онд хонины амьдын жин 1-2 кг, үхрийнх 30 кг-р буурсан
- 1990-2016 онд богийн гулуузны жин 13.9% буурсан /ХХААХҮЯ, 2018/
- Мал нь улсын нийт хүлэмжийн хийн 48.5% ялгаруулж гол “бохирдуулагч” болсон
- Хил дамнасан өвчний гаралт буурахгүй, экспортод мөргөөр нөлөөлж байна

- Бэлчээрийн даац их хэтэрснээс гулуузны чанар муудаж, өөхний хувийн жин нэмэгдэж, махны хувийн жин буурч байгаагаас экспортын зах зээлд үнэлгээ нь унаж байна. Ийнхүү малын амьдын жин буурсны алдагдал 14%, гулуузны чанар муудсаны 33%-г нийлүүлж нийт одоогийн мал нь бэлчээрийн тэжээл бүрэн хангамжтай байх үеийн малтай харьцуулбал 42% алдагдалтай болсныг дор харуулав.

Зураг 2 Бэлчээрийн даац хэтрэлт, тэжээлийн архаг дутагдлаас малын ашиг шим, үнэ цэнэ буурч байгаа нь



2. Хурга борлуулах нь малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, бэлчээрийн ачааллыг бууруулах загвар болох нь

Жилээс жилд мал сүргийн тоо өсөөд байгаагийн бодит шалтгаан нь нэгж малаас авах ашиг шимийн бууралттай холбоотой бөгөөд энэ нь бэлчээрийн даац муудаж дутмаг тэжээллэгтэй байгаагаас үүдэн мал тухайн насныхаа жинд хүрэхгүй байгаагаас өсвөр бага насны буюу төлөг, борлонгийн борлуулалт үндсэндээ байхгүй болж нас гүйцсэн буюу 4 нас хүрч байж борлуулах жинд хүрч байгаагаас бэлчээрт байх малын тоо толгой өсөж, олшрох гол хүчин зүйл болж байна.

Бэлчээрийн маллагааны нөхцөлд монгол хурга хуанлийн 10-11 сард амьдын жин оргил үедээ 37 кг жинд хүрдэг хэдий ч энэхүү жингээ 20 гаруй хувиар алдаж онд ороод, дараа оны хавар 4-5 сараас эхэлж жингээ нэмэгдүүлснээр зун 7-8 сараас эхлэн борлуулалтад ордог байна.

Гэвч сүүлийн жилүүдийн бэлчээрийн даац хэтэрч, дутуу хооллолттой холбоотойгоор төлөгний амьдын жин 30 кг жинд хүрдгүй тул төлөгний борлуулалт байхгүй болж хонийг шүдлэн, хязгаалан насанд хүргэж борлуулах болсноор сүрэгт эзлэх таваарын мал нэмэгдэж, бэлчээрт байх малын тоо өсөөд байна.

Малчдын ашиг орлогыг бууруулахгүйгээр малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх дөт зам нь хонийг эрт төллүүлэн, төллөсөн эх малыг тэжээж жилбэшүүлэн, сүү шимээр дамжуулан хургыг махлуулан эдийн засгийн эргэлтэд оруулах явдал юм.

Ингэснээр малыг бэлчээрт заавал 3-4 жил барих шаардлагагүй болж, бэлчээрээ олон малаас чөлөөлж хамгаалах боломжтой болох юм /Зураг 3/.

Зураг 3 Хонины амьдын жингийн өөрчлөлт, жилээр, кг



3. Хурга борлуулах нь мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх загвар болох нь

Хурга борлуулах тооцоог хонин сүргийн эргэлтийг үндэслэн 4 хувилбараар гаргав. Үүнд малын тоог жилд дунджаар 10% өсгөж байгаа сүүлийн жилүүдийн нөхцөл /А хувилбар/-г малын тоог өсгөхгүйгээр барьж, эр хургыг түлхүү борлуулах 3 хувилбар /Б-Г хувилбар/-тай харьцуулав.

Хурга борлуулах боломж нь сүрэгт эзлэх эх малын хувийн жингээс шууд хамааралтай байдаг тул эх малын хувийн жин одоогийн 45% орчим байгаа нөхцөлд эр хурганы 6%, охин хурганы 3%-г л борлуулах боломжтой бол эх малын хувийн жинг өсгөх дутам борлуулах боломжтой хурганы тоо, үүнийг дагаад мах үйлдвэрлэл эрс нэмэгдэж байна /Хүснэгт 1/.

Хүснэгт 1 Хурга борлуулснаар мах үйлдвэрлэл, орлого нэмэгдэж, шаардагдах бэлчээрийн тэжээлтийн хэрэгцээ багасгах нь, 100 хонь дутам

	Сүрэгт хээлтэгчийн эзлэх хувь	Хурга борлуулах хувь	Мах үйлдвэрлэл, кг	Шаардагдах бэлчээрийн тэжээлийн хэрэгцээ			Махны орлого, сая төгрөг	Малчдын махны орлогын өсөлт	
				Нийт гэжээл, цн	Нийт талбай, га	100 кг мах үйлдвэрлэхэд шаардагдах бэлчээр, га		Хувиар	Сая төгрөгөөр
А	45%	Үгүй	526	607	289	55	3.58	-	-
Б	45%	Эр 6%, Охин 3%	709	584	278	39	4.82	34.7%	1.24
В	60%	Эр 72%, Охин 5%	884	602	287	32	6.01	68.0%	2.43
Г	70%	Эр 95%, Охин 16%	1001	614	293	29	6.81	90.3%	3.23

Тайлбар: А - одоогийн нөхцөл, малаа жилд 10% өсгөнө, хурга борлуулахгүй, Б - малаа өсгөхгүй, тогтмол хэмжээнд барьж, хурга борлуулна, В - малаа өсгөхгүй, тогтмол хэмжээнд барьж, хурга борлуулна. Малчдын борлуулж буй махны 1 кг-н үнийг 2019-2021 оны 3 жилийн улсын дундаж 6800 төгрөг, бэлчээрийн ургацыг 2016-2020 оны 5 жилийн улсын дундаж ургац 2.1 цн, махлуулсан эр

хурганы намрын амьдын жинг дунджаар 42.5 кг (нийт махлуулсан эр хурганы 50% нь 45 кг, 50% нь 40 кг хүрэх тооцоо), нядалгааны гарцыг 43%-р тус тус тооцов.

А-с Г-д шилжих дутам мах үйлдвэрлэл нэмэгдэж, шаардагдах бэлчээр багасан бүтээмж, орлого нэмэгдэж байна. Тухайлбал ижил 100 кг махыг Г хувилбараар 29 га бэлчээрт үйлдвэрлэж байгаа нь одоогийн нөхцөл болох А хувилбарын 55 га-аас 26 га-аар бага буюу бэлчээрийн хэрэгцээг 47% бууруулж байна.

Хамгийн гол нь малчдын мах үйлдвэрлэлээс олох орлого 100 хонь дутам одоогийнхоос 1.2-3.2 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Одоогийн нөхцөлд 100 хониноос үйлдвэрлэж байгаа 526 кг махыг хурга борлуулах загвараар 52 хониноос үйлдвэрлэх боломжтой байгаа нь хонины тоог 48%-р бууруулахад мах үйлдвэрлэлийг одоогийн хэмжээнд хадгалах боломжтой гэсэн үг юм. Энэ нь 2021 онд тоологдсон 31.1 сая хонийг 14.9 сай толгойгоор бууруулж, 16.2 сая болгох боломж олгож байна. Ингэснээр нийт малын тоог хонин толгойд шилжүүлснээр одоогийн 115.3 саяас 100.4 сая болгож 13.4%-р бууруулж, энэ хэмжээгээр бэлчээрийн даац хэтрэлт, малын хоол тэжээлийн дутагдал, малаас ялгарах хүлэмжийн хий багасах юм.

4. Хурга борлуулах нь цөөн малаас илүү орлого олж малчдын амьжиргааг дээшлүүлэх загвар болох нь

Сүүлийн жилүүдэд малын тоо их өссөн нь малчдын амьжиргааг тэр хэмжээгээр дээшлүүлж чадав уу гэвэл бодит баримт үгүй гэсэн хариулт өгч байна. Дэлхийн банкны мэдээлснээр 2014 оноос 2016 оны хооронд ядуурал 27.1 хувиас 34.9 хувь болж 8 пунктээр нэмэгдсэн бөгөөд хөдөөгийн ядуурал хот суурин газрынхаас ямагт өндөр байсаар иржээ.

Малыг тооны өсөлтийг дагаад малчдын амьжиргаа тогтвортой дээшлэхгүй байгаагийн шалтгаан нь дээр дурдсан бэлчээрийн тэжээлийн дутагдлаас үүдэн малын ашиг шим, чанар, зах зээлийн үнэ цэнэ буурч байгаатай холбоотой юм. Түүнчлэн хоол тэжээлийн дутагдлаас мал нь ган, зуд, уур амьсгалын өөрчлөлт зэрэг байгалийн эрсдэл, өвчнийг тэсвэрлэх чадвар нь муудаж, илүү эмзэг болсон нь ч их нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл өнөөгийн малчид малаа өсгөх гэж хоёр зудын хооронд гадаа гандаж, хөдөө хөхрөөд үр дүнд нь хожсон зүйл бага, харин ч бэлчээрээ талхалж, отрын бэлчээрээ үгүй хийснээс дараагийн ган, зудаар бүр ч илүү хохирдог “чөтгөрийн тойрог”-т хий эргээд удаж байна.

Харин хургыг борлуулах замаар МАА-н үндэс болсон бэлчээрээ хамгаалж, малчдын амьжиргааг урт хугацаанд тогтвортой дээшлүүлэх боломжтой юм. Үүнийг хургыг махлуулах туршилтын ажлын эдийн засгийн тооцооноос харж болно.

Хургыг намар 45 кг амьдын жинд хүргэх зорилгоор:

- Махны чиглэлийн Баяд хуцыг хээлтүүлэгчээр ашиглах
- Төллөсөн эр хургатай эх хонийг хоногт 250 грамм сайн чанарын хүчит тэжээлээр 45 хоногийн хугацаанд нэмэгдлээр тэжээж, эхийг жилбэшүүлэхийн зэрэгцээ бэлчээрт явах зайг багасгах замаар дагасан хурганы явдлыг багасгаж махлуулах

- Хургыг 7-р сарын сүүлчээр хургыг эхээс нь ялгаж тусад нь суурь зохион байгуулж сайн бэлчээрт оторлох ажлыг гүйцэтгэнэ
- Тэжээлийн зардалд 100 хонь тутамд тооцож 1.1 сая төгрөг, хурганы маллагааны хөлсөнд сарын 0.3 сая төгрөг, гурван Баяд хуц худалдан авахад 0.9 сая төгрөг нийт гарсан зардал 2.3 сая төгрөгийн зардал гарч байна.

Хургыг махлуулж борлуулснаар мах үйлдвэрлэлээс малчдын олох нэмэгдэл орлого сүрэгт эзлэх эх малын хувийн жин 70% байхад 3.23 сая төгрөг болж байгаа билээ. Дээрх нэмэгдэл орлогоос хурганы мах үйлдвэрлэхэд гарах зардал 2.3 сая төгрөгийг хасвал малчид 100 хонь тутам 0.9 сая төгрөгийн цэвэр орлого буюу ашиг олохоор байна. Хурганы мах үйлдвэрлэлийн орлого, ашгийн тооцоог 500 хоньтой малчин өрхийн жишээн дээр харьцуулан гаргав.

Хүснэгт 2 500 хоньтой малчин өрхийн хонины махны орлогын харьцуулалт

Үзүүлэлт	Одоогийн нөхцөлд	Эх малын хувийн жинг 70% хүргэж хурга борлуулснаар
Малын тоо, толгойгоор	500	500
Үйлдвэрлэх мах, тонн	2.63	5.0
1 кг махны үнэ, төгрөг	6800	6800
Махны нийт орлого, сая төгрөг	17.9	34.0
Хурга махлуулах зардал, сая төгрөг	-	11.5
Бусад шууд зардал*	5.3	5.3
Нийт зардал	5.3	16.8
Цэвэр орлого	12.6	17.2

*Үүнд тэжээл, мал эмнэлэг, тээвэр, шатахуун, хариулгын хөлс багтсан бөгөөд хоёр дахь эх үүсвэрийн судалгааны материалыг ашиглав. Харин малчин өрхийн амьжиргааны зардал ороогүй болно.

Хурганы мах үйлдвэрлэхийн давуу тал нь бэлчээрийн ачааллыг бууруулж, махны нийлүүлэлт, малчдын орлогыг нэмэгдүүлэхээр хязгаарлагдахгүй юм. Хурганы мах нь холестерин бага тул зүх судасны өвчлөл өндөр Монгол орны хүн амын эрүүл мэндэд ихээхэн ач холбогдолтой юм. Хурганы махны эрүүл мэндийн давуу давуу тал:

- Зүрх судасны өвчний нэг шалтгаан болсон холестерин 100 грамм хурганы маханд 96 мг байдаг нь нас гүйцсэн хонины махнаас 13 мг-р бага
- Өөхөн судлын хэмжээ бага, өөхний 64% нь эрүүл мэндэд хоргүй ханаагүй өөх байдаг
- Өндөр чанартай уураг, В аминдэм, цайр, төмөр зэрэг эрдсээр баялаг
- Хүний биед нэн чухал 8 төрлийн амин хүчлийг хамгийн зөв харьцаатайгаар агуулдаг
- Хүний бие организм бий болгож чаддаггүй нийлмэл линолений хүчлийг агуулдаг нь хоргүйжүүлэх (anti-oxidant), дархлааг сайжруулах үйлчилгээтэй байдаг байна.

Эрүүл мэндийн давуу талын улмаас хөгжингүй орнуудын зах зээл дээр нас гүйцсэн хонины махнаас хурганы мах гуравны нэгээр илүү үнэтэй байдаг тул махны экспортын орлогыг нэмэгдүүлэх боломжтой.

5. Үндэсний эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө

Хурганы мах үйлдвэрлэлийн байгаль орчин, эдийн засгийн эрэг нөлөө их. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлснээр мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжлийн замд оруулж, биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд засан зохицохын гадна махны хангамж, үнийг тогтворжуулж, хүн амын эрүүл мэндийг сайжруулах чухал алхам болно. Энэ бүгдийн эдийн засгийн үнэ цэнэ жилийн хэдэн зуун тэрбумаар хэмжигдэх юм.

Иймд хурганы мах үйлдвэрлэх загварыг үндэсний хөтөлбөрийн хэмжээнд орон даяар нэвтрүүлэх шаардлагатай байна. Үүнд дээр дурдсан 16.2 сая хониор тооцвол эр хурга бүхий 5.7 сая эм хонийг тэжээхэд жилдээ 63.8 мянган тонн сайн чанарын хүчит тэжээл шаардагдана.

Хурганы мах үйлдвэрлэх загварыг сайн чанарын тэжээл үйлдвэрлэл, хуцын хангамж, малчид, хэрэглэгчдэд ойлгуулах сургалт, сурталчилгааны цогц ажлыг багтаасан хөтөлбөр хэлбэрээр улс, орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрт санхүүжилтийг тусган шат дараатай хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

БОДЛОГО СУДЛАЛЫН ТӨВ

www.cpr.mn